



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 20 -ны өдөр

Дугаар 1/52

Эрдэнэт

“Цахим системд мэдээлэл оруулах
ажилтныг томилох тухай”

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Гамшгаас хамхаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үед цахим мэдээний системд мэдээлэл оруулах ажилтнуудын нэрсийг хавсралтаар баталсугай.
2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үеийн цахим мэдээний системд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл технологи, цахим эрүүл мэнд, сүлжээ хариуцсан мэргэжилтэн /Оюун-эрдэнэ/-д, цахим мэдээний чанар, үнэн зөв байдал, мэдээллийг холбогдох хугацаанд оруулахыг Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.
3. Хавсралтад заагдсан албан хаагчид Эрүүл мэндийн сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгаврын дагуу цахим мэдээний системд оруулсан мэдээлэл, авсан арга хэмжээ, гарсан үр дүнгийн тайланг сар бүрийн 03-ны дотор гаргаж Мэдээлэл технологи, цахим эрүүл мэнд, сүлжээ хариуцсан мэргэжилтэн /Оюун-эрдэнэ/-д ирүүлсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

№	Цахим системийн нэр	Мэдээлэл оруулах ажилтны албан тушаал, нэрс	Гүйцэтгэх үүрэг	Мэдээ оруулах хугацаа
1	burtgel.mohs.mn	Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ, эм эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтэн О.Анхбаяр	Коронавируст халдварын үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуурын орлого, зарлагын мэдээлэл	Өдөр бүр
	tandalt.gov.mn	Амьсгалын замаар дамжих халдвар, сүрьеэгийн тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн Б.Билгүүнээ БОЭТ-ийн статистик мэдээллийн албаны дарга М.Бурмаа	Коронавируст халдварт өртсөн хүмүүсийн тандалт, тусгаарлан ажиглах байрны мэдээ Коронавируст халдвараар хэвтэн эмчлүүлэгчдийн орны мэдээ	Тухай бүр
2	eruul.gerege.mn	Мэдээлэл технологи, цахим эрүүл мэнд, сүлжээ хариуцсан мэргэжилтэн Х.Оюун-Эрдэнэ	ПГУ шинжилгээний бүртгэл, лабораторийн үйл явц, эргэн мэдээлэл,	Өдөр бүр
3	health.gov.mn	Дархлаажуулалт, зоонозын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Энхтүвшин	Коронавируст халдварын дархлаажуулалтад хамрагдсан иргэдийн мэдээлэл	Тухай бүр
4	burtgel.mohs.mn	Эрүүл мэндийн байгууллагын статистик, мэдээ мэдээлэл хариуцсан ажилтан С.Эрдэнэцэцэг	Эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээллийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаалаар батлагдсан “Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээ” АМ-36 маягтаар	Өдөр бүр
5	H-info	БОЭТ-ийн статистик мэдээллийн албаны дарга М.Бурмаа	Коронавируст халдвараар хэвтэн эмчлүүлэгч, нас баралтын мэдээлэл	Тухай бүр
6	H-info	Эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн Г.Итгэл	Хэвтэн эмчлүүлсэн тухай эмнэлгийн магадлагааг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дүгээр тушаалаар батлагдсан “Эмнэлгийн магадлагаа” АМ-8 маягтаар оруулж мэдээллийн сан үүсгэхэд хяналт тавих	Тухай бүр